



БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ  
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

# ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2024 СУУРЬ БОЛОВСРОЛ



# ТҮҮХ

*ХУВИЛБАР А*

Аймаг / дүүрэг: .....

Сум / сургууль: .....

Анги / бүлэг: .....

Сурагчийн овог: .....

Сурагчийн нэр: .....

Сурагчийн код: .....



### САНАМЖ

- Даалгаврыг 40 минутад гүйцэтгээрэй.
- Даалгавар тус бүрээс зөвхөн нэг хариултын хувилбарыг сонгож, хариултын хуудсанд зааврын дагуу балын харандаагаар будаарай.

1. Дэлхийн түүхийн үечлэлээр дундад зууны үе хэдээс хэддүгээр зууныг хэлдэг вэ?

- A. НТӨ V зуун – НТӨ XV зуун      B. НТ V зуун – НТ XV зуун  
C. НТӨ I зуун – НТӨ XV зуун      D. НТ I зуун – НТ XV зуун

2. Монголчууд билгийн тооллыг аргын тооллын 1027 оноос эхэлж тоолох болсон. Энэ он нь хэддүгээр зуунд хамаарах вэ?

- A. НТӨ X зуунд      B. НТӨ XI зуунд      C. НТ X зуунд      D. НТ XI зуунд

3. Он тооллын шугамд тэмдэглэсэн онуудад түүхэн ямар үйл явдлууд болсон бэ?

Он тооллын шугам:



- A. Тэмүжин мэндэлсэн, Чингис хаан Их Монгол улсыг байгуулсан.  
B. Тэмүжин хаан болов, Наху гүнд Найманыг ялав.  
C. Улз голд Татарыг довтлов, Далан нөмрөгт Татарыг довтлов.  
D. Тэмүжин Мэргидийн довтолгоонд өртөв, Мау өндөрт Хэрэйдтэй байлдав.

4. “Татар хүний бие бялдар өндөр бус, хамгийн өндөр нь таван тохой хоёр ямхаас давахгүй” гэсэн сурвалжийн мэдээг ашиглан татар хүний өндрийг тооцоолон олно уу. (нэг тохой 35 см орчим, ямх-3.2 см)

- A. 181.4 см      B. 175 см      C. 156.4 см      D. 171.4 см

5. X-XII зууны ихэнх Монгол аймгууд ямар шашин шүтлэгтэй байсан бэ?

- A. Бөөгийн шашин      B. Христийн шашин  
C. Исламын шашин      D. Буддын шашин

6. Эдгээрээс бичгийн эх сурвалжид хамаарах дурсгал аль нь вэ?

- A. Хархорум хотын туурь      B. Өгэдэй хааны зоос  
C. Газан хааны бунхан      D. Чингисийн чулууны бичиг

7. Хубилай хаан аль шашныг Юань улсын төрийн шашин болгосон бэ?

- A. Бөөгийн шашин      B. Лалын шашин  
C. Бумбын шашин      D. Бурхны шашин

8. Ямар шашин Коран судрын сургаалыг баримталдаг вэ?

- A. Буддын шашин      B. Лалын шашин  
C. Загалмайн шашин      D. Хиндү шашин

9. Япончуудын шүтдэг нарны бурхан Аматаэрасу нь аль шашны бурхан бэ?

- A. Загалмайн шашин      B. Лалын шашин  
C. Шинто шашин      D. Индус шашин



10. Багдад, дамаскт одон орныг судлах төв байв. Тэдний судлаачин одон орон судлалд нар бол ертөнцийн төв, дэлхий түүнийг тойрон эргэнэ гэсэн таамаглал хэн дэвшүүлсэн бэ?  
А. Мухаммед                      В. Ибн Сина                      С. Абу Бекр                      D. Аль-Бируни
11. Цэгийн оронд тохирох хариултыг нөхөж бичнэ үү.  
Тан улсын хаан Ли Ши Миний үеэс Даогийн шашин нөлөөгөө алдаж, Хятадад ..... шашин хүчтэй дэлгэрсэн юм.  
А. Күнзийн                      В. Индусын                      С. Бурхны                      D. Исламын
12. Уг томъёог ашиглаж дасгалаа хийгээрэй.                      ( $x=M-M/33+622$ )  
Хижрийн тооллын 1300 он нь аргын тооллын хэдэн он болох вэ?  
А. 655 он                      В. 661 он                      С. 1883 он                      D. 1922 он
13. 1526 онд Төмөрийн угсааны Бабур Энэтхэгт ямар улсыг эзэлж, Их Могол улсыг байгуулсан бэ?  
А. Маурын эзэнт гүрэн                      В. Делийн султант  
С. Гуптагийн гүрэн                      D. Мавереннахр
14. Одоогийн Перу улсын нутагт орших Куско хотыг дундад зууны үед ямар хүмүүс барьж байгуулсан бэ?  
А. Ацтек                      В. Майя                      С. Инк                      D. Викинг
15. Европт хааны тушаалаар цэргүүдтэйгээ ямар хүмүүс дайнд ордог байсан бэ?  
А. Самурайнууд                      В. Санваартнууд                      С. Ацтекууд                      D. Герцог
16. Дундад зууны Европын Католик сүмийн лам нар ямар хэлээр ном айлддаг байсан бэ?  
А. Грек                      В. Латин                      С. Перс                      D. Англи
17. 1088 онд Европт анхны их сургуулиуд байгуулагджээ. Энэ үйл явдал хэддүгээр зуунд болсон бэ?  
А. IX зуунд                      В. X зуунд                      С. XI зуунд                      D. XII зуунд
18. Загалмайн шашны Үнэн алдартны сүм хийдийн тэргүүнийг юу гэж нэрлэдэг вэ?  
А. Пап                      В. Патриарх                      С. Хутагт                      D. Гэлэн
19. Майячууд Америк тивийн хаагуур нутаглаж байсан бэ?  
А. Төв Америкийн Юкатаны хойгоор  
В. Хойд Америкийн төв хэсэг одоогийн Мексик улсын нутгаар  
С. Одоогийн Перу улсын нутаг, Өмнөд Америкийн баруун эргийн Андын нуруугаар  
D. Өмнөд Америкийн Амазон мөрний хөндийгөөр
20. Монголын нууц товчоонд бичснээр Чингис хаан 1206 онд Их Монгол улс байгуулагдсаныг зарлан тунхагласан Их хуралдайг хаана хийсэн бэ?  
А. Хар зүрхний Хөх нуур орчим                      В. Буйр нуурын орчим  
С. Хэрлэн мөрний Хөдөө аралд                      D. Онон мөрний эхэнд



21. Ази ба Европ тивийг дамнасан “Монголын энх амгалан” гэдэг үзэл суртлын үндсийг тавигч нь хэн бэ?  
А. Өгэдэй хаан      В. Хубилай хаан      С. Гүюг хаан      D. Чингис хаан
22. 1246 онд Гүюг Их Монгол улсын хаан болов. Уг үйл явдал нь Чингисийн тооллын хэдэн онд болсон бэ?  
А. 85      В. 24      С. 40      D. 2452
23. 1247 онд Гүюг хаан өмнөд Сүн улсыг эзлэх аян дайныг эхлүүлэв. Уг үйл явдал НТ-ын хэддүгээр мянган хэддүгээр зуунд болсон бэ?  
А. II мянганы XII зуунд  
В. I мянганы XIII зуунд  
С. II мянганы XIII зуунд  
D. I мянганы XII зуунд
24. 1279 онд Хубилай хаан өмнөд Сүн улсыг эзэлж дууссанаар бүх Хятад Монголчуудын мэдэлд оржээ. Уг үйл явдал хэддүгээр жаранд болсон бэ?  
А. 3-р жаран      В. 4-р жаран      С. 5-р жаран      D. 6-р жаран
25. “Их хааны мөнгө, зоос хийх газар байдаг. Бүх цаасан мөнгөн дээрээ их хааны тамгыг дардаг байжээ.” гэж ямар сурвалж дээр бичсэн байдаг вэ?  
А. Юань улсын судар  
В. Дорно этгээдэд зорчсон минь  
С. Орчлонгийн элдэв сонин  
D. Судрын чуулган